



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ  
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ  
/ДОА-2018-02-НА/**



**Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийг даатгалд  
бүрэн хамруулаагүй байна.**

Чойбалсан хот  
2018 он

Тайланг бэлтгэсэн:  
Дорнод аймаг дахь Төрийн  
аудитын газрын Нийцлийн  
аудитын алба

Дарга бөгөөд Тэргүүлэх  
аудитор Б.Болортуул  
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд  
аудитын менежер  
В.Цэнгэлмаа  
Утас: 70584207

Аудитор  
Б.Батжаргал  
Б.Одхүү  
Утас: 70584207

2018 оны 09 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70584207 дугаарын  
утас, [www.audit.mn](http://www.audit.mn)  
цахим хаягаар  
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,  
Хэрлэн сум, 7-р баг,  
аймгийн ЗДТГ-ын 2-р  
байр, 1 давхар 02 тоот

## Агуулга

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**I Бүлэг. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийг даатгалд бүрэн хамруулаагүй байна.**

1.1 Сангийн орлогыг төлөвлөхдөө хуульд заасан албан журмын даатгуулагчдыг бүрэн хамруулаагүй байна.

1.2 Төрөөс хариуцах иргэдийн шимтгэлийн санхүүжилт бүрэн хийгдээгүй байна.

**II Бүлэг. Сумдад сангуудын төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй байна.**

2.1 Нийгмийн даатгалын сангуудын зардлыг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

2.2 Сангуудын орлого, зарлагын гүйлгээн дээр сумын Засаг дарга гарын үсэг зурсан байна.

**III Бүлэг. Сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.**

3.1 Сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

3.2 Хяналт шалгалтаар тавигдсан төлбөрийн барагдуулалт 80 хувьтай байна.

## ДҮГНЭЛТ

### ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН

### ХАРИУ

### ЗӨВЛӨМЖ

### ТУШААЛ

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>НАГ</b>	Нийцлийн аудитын газар
<b>НА</b>	Нийцлийн аудит
<b>ДОА</b>	Дорнод аймаг
<b>НДЕГ</b>	Нийгмийн даатгалын ерөнхий газар
<b>НДҮЗ</b>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
<b>НДХ</b>	Нийгмийн даатгалын хэлтэс
<b>НДС</b>	Нийгмийн даатгалын сан
<b>НД</b>	Нийгмийн даатгал
<b>ХЧТА</b>	Хөдөлмөрийн чадвар түр алдалт
<b>ЖА</b>	Жирэмсэн, амаржсан
<b>ҮОМШӨ</b>	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
<b>БОЭТ</b>	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
<b>ЭМД</b>	Эрүүл мэндийн даатгал
<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2018 оны А/6 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### Аудитын зорилт:

Нийгмийн даатгалын сангуудын үйл ажиллагаан дахь хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитыг дараах дэд зорилтуудын хүрээнд хийлээ. Үүнд:

- *Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх*
- *Нийгмийн даатгалын сангийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх*
- *Сангуудын үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх.*

### Аудитын хамрах хүрээ

Дорнод аймгийн Нийгмийн даатгалын сангуудын 2017 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримт, холбогдох материалыг хамрууллаа.

### Үндсэн мэдээлэл:

“Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ мөн” гэж Нийгмийн даатгалын тухай хуульд заажээ.

Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2017 онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 22543,3 сая төгрөгөөр төлөвлөж, 23357,8 сая төгрөгийг төвлөрүүлэн төлөвлөгөөг 103,6 хувиар биелүүлж ажилласан байна. Төрөөс тэтгэврийн даатгалын шимтгэлд 25611,9 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж 24935,3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Нийгмийн даатгалын сангуудын зарлагыг 47393,8 сая төгрөгөөр төлөвлөж, 46786,4 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөгөөг 98,7 хувиар биелүүлж ажилласан байна.

Нийгмийн даатгалын хэлтэс үйл ажиллагаандаа ISO 9001-2008 стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэн тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн төлөө тасралтгүй сайжруулалтыг хийж ажилтнуудын харилцааны болон үйлчилгээний соёл мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн ажилласнаар үйл ажиллагааны чанар сайжирч “Олон улсын ISO 9001-2008 стандартад нийцсэн Чанарын удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн байгууллага” гэсэн чанарын гэрчилгээг авсан байна.

## **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-4000, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

## **Аудитын шалгуур үзүүлэлт**

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- *Төсвийн тухай хууль*
- *Нийгмийн даатгалын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай*
- *Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай*
- *Иргэний эрүүл мэндийн тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль*
- *Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль*
- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль*
- *Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд*

## **Аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, аудитор Б.Батжаргал, Б.Одхүү нар гүйцэтгэлээ.

## **Аудитын хугацаа**

Аудитыг 2018 оны 05 дугаар сарын 01-ий өдрөөс эхэлж 09 дүгээр сарын 24-ний өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

## **Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам**

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

I Бүлэг. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийг даатгалд бүрэн хамруулаагүй байна.

1.1 Сангийн орлогыг төлөвлөхдөө хуульд заасан албан журмын даатгуулагчдыг даатгалд бүрэн хамруулаагүй байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.4.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2009 оны 19 дүгээр тогтоолын дагуу 2017 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг тус байгууллагын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан батлагдсан маягт зааврын дагуу боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн байна.

Тодотгосон төсвийг анхны төсөвтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Үзүүлэлт			/сая.төг/	/Хүснэгт 1/
	Төсвийн төсөлд өгсөн санал	Анх батлагдсан төсөв	Тодотгож батлагдсан төсөв	Батлагдсан төсвийн зөрүү
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	3753,9	4374,7	5477,6	1102,9
Даатгуулагчийн төлөх шимтгэл	7319,7	8610,5	8738,5	127,9
Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	4672,3	5055,7	4660,7	(394,9)
Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэл	1641,6	1538,1	1538,1	
Нөхөн олговор авагчдын шимтгэл	0	0	0	
Гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн	0	0	0	
ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэл	20,5	18,4	18,4	
ЭМД-ын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	595,7	671,6	671,6	
Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	1625,3	1432,9	1432,9	
Бусад орлого	5,2	5,5	5,5	
<b>Нийт орлого</b>	<b>19634,3</b>	<b>21707,5</b>	<b>22543,4</b>	<b>835,9</b>

Нийт төсвийг анх төсөвлөсөн дүнгээсээ 835,9 сая төгрөгөөр нэмж баталсан нь оны эцэст Улсын Их Хурлын 67 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад ажлын үр дүнгийн урамшуулал олгох болсонтой холбоотой байна.

Орлогын нэр төрлүүдээс нөхөн олговор авагчдын шимтгэл, гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн орлогуудыг төлөвлөөгүй байна. нөхөн олговор авагчдын шимтгэлийн хувьд 1990-1995 онуудад тэтгэвэрт гарах нас хүрээгүй боловч тухайн үеийн хуулийн дагуу тэтгэвэрт гарсан иргэдээс нөхөн олговор авагчдын шимтгэл авч байсан байна. Одоо эдгээр иргэд нь хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон шимтгэл төлөхөөс хасагдсан тул шимтгэлийн орлогыг авахгүйгээр төлөвлөсөн байна. Гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн шимтгэлийг тухайн оронтой байгуулсан гэрээний дагуу НДЕГ-т төвлөрүүлдэг учраас шимтгэлийн орлогыг төлөвлөөгүй байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д: Нийгмийн даатгалд дор дурдсан ажилтан албан журмаар даатгуулна. гэж заасан Үүнд:

1. өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
3. хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч;
4. хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн.

Дээрх хуулийн 4.2.1 дэх заалтад хамаарах өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсад даатгалд бүрэн хамрагдсан эсэхийг Татварын хэлтэс дэх цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос татвар төлөгч иргэдийн мэдээлэлтэй тулган шалгалаа.


Тулгалтаар Татварын хэлтэс дэх 163 аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл нийгмийн даатгалын хэлтсийн бүртгэлд байхгүй, ажиллагсад нь нийгмийн даатгалд хамрагдаагүй байна.

Эдгээр байгууллага нь 282 татвар төлөгчийн 549,0 сая төгрөгийн татвар ногдуулах орлогоос 54.9 сая төгрөгийн татвар ногдуулахаар цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татварын тайлан ирүүлсэн байна. Нийгмийн даатгалын хэлтэс нь эдгээр иргэдийг нийгмийн даатгалд хамруулахаар төлөвлөж, хамруулаагүйгээс 115,3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломж алдагдсан байна.

## **1.2 Төрөөс хариуцах иргэдийн шимтгэлийн санхүүжилт бүрэн хийгдээгүй байна.**

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын 5 санд 22543,3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 23399,1 сая төгрөгийн орлого хуримтлуулж төлөвлөгөөг 3,8 хувь буюу 855,8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.


/сая.төг/ /график 1/



Нийгмийн даатгалын сангуудын нийт орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн боловч сангуудаар авч үзвэл ЭМД 93,8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 18,9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь ЭМД-ыг төрөөс хариуцах иргэдийн санхүүжилт 2017 онд Сангийн яамнаас дутуу орсон, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 2017 онд 0,8-иас 0,2 хувь болгон бууруулснаас шалтгаалсан байна.

Сангуудын орлогыг шимтгэл төлөгчдийн эзлэх хувиар үзүүлбэл:

/график 2/



Дээрх графикаас харахад төсөвт байгууллагын төлсөн шимтгэл, аж ахуй нэгж, байгууллагын ажил олгогчийн төлсөн шимтгэл орлогын ихэнх 48 хувийг эзэлж байна.



Сангуудын орлогын төсвийн гүйцэтгэлийг үзүүлбэл:

Орлогын төрлөөр	Төлөвлөгөө	/сая.төг/ /Хүснэгт 2/	
		Гүйцэтгэл	Зөрүү
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	5477,6	4534,1	943,5
Ажиллагсадаас төлөх шимтгэл	8738,5	8593,7	144,8
Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	4660,7	6719,5	-2058,8
Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэл	1538,2	1614,2	-76,0
Төр бүрэн хариуцах даатгуулагчийн шимтгэл	1432,9	1390,3	42,6
Бусад даатгуулагчаас төлсөн шимтгэл	671,6	485,6	186,0
ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэл	18,4	18,4	0,0
Бусад орлого	5,5	45,5	-40,0
<b>Нийт</b>	<b>22543,4</b>	<b>23401,3</b>	<b>-857,9</b>

Төсөвт байгууллагын төлөх шимтгэлийн орлогын биелэлт нь бусад төлөгчдийн шимтгэлийн орлогын тасралтыг нөхсөн нь нийт орлогын төлөвлөгөө биелэхэд голлох нөлөө үзүүлсэн байна.

**II Бүлэг. Сумдад сангуудын төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй байна.**

**2.1 Нийгмийн даатгалын сангуудын зардлыг үндэслэлтэй төлөвлөсөн байна.**

Нийгмийн даатгалын 5 сангийн зарлагаас тэтгэврийн даатгалын сан 0,2 хувиар хэтэрч, бусад сангийн зарлага 0,2 - 8,6 хувиар хэмнэгдсэн байна.

*Тэтгэврийн даатгалын санд хамрагдагсадыг төсөвтэй нь харьцуулж харуулбал:*

	Хүний тоо			2017 он /сая.төг/			
	2016 он	2017 он	Өсөлт, бууралт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Биелэлт хувь
Өндөр насны	7347	7672	325	26699,1	26693,4	-5,7	100
Тахир дутуугийн	2484	2670	186	7314,9	7286,3	-28,6	99,6
Тэжээгчээ алдасны	647	634	-13	1766,8	1805,8	39	102,2
Цэргийн	487	517	30	2916,2	2985,7	69,5	102,4
	<b>10965</b>	<b>11493</b>	<b>528</b>	<b>38697,0</b>	<b>38771,2</b>	74,2	100,2

Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 74,2 сая төгрөгөөр хэтэрсэн нь тэтгэвэр авагчдын тоо нэмэгдсэн, тэтгэвэр авагч нь аль өндөр илтгэлцүүр сонгох боломж бүрдсэнтэй холбоотой байна.

Мөн ажилласан жил нөхөн тооцох нөхцөлөөр 78 тэтгэвэр авагчийн тэтгэврийг, нийгмийн даатгалын хуулийн шинэчилсэн заалтын хүрээнд дундаж цалинг өөрчилсөн, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч иргэд ажилласан жил нөхөн тооцох хуульд хамрагдаж 31 иргэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүссэн зэрэгтэй холбоотой байна.

Тэтгэмжийн даатгалын санд хамрагдагсадыг төсөвтэй нь харьцуулж харуулбал:

/Хүснэгт 4/

	Хүний тоо				2017 он /сая.төг/		
	2016 он	2017 он	Өсөлт, бууралт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Биелэлт хувь
ХЧТА	2112	2651	539	238,5	282,5	44,0	118,4
ЖА	1402	1417	15	1351,4	1295,2	(56,2)	95,8
Оршуулгын тэтгэмж	426	384	(42)	397,0	384,0	(13,0)	96,7
	<b>3940</b>	<b>4452</b>	<b>512</b>	<b>1986,9</b>	<b>1961,7</b>	<b>(25,2)</b>	<b>98,7</b>

Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 25,2 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь оршуулгын тэтгэмж өмнөх онтой харьцуулахад 42 иргэнээр буурсантай холбоотой байна.

ҮОМШӨ-ний даатгалын санд хамрагдагсадыг төсөвтэй нь харьцуулж харуулбал:

/Хүснэгт 5/

	Хүний тоо				2017 он /сая.төг/		
	2016 он	2017 он	Өсөлт, бууралт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Биелэлт хувь
Тэтгэвэр	79	80	1	382,9	354,8	(28,1)	92,7
ХЧТА тэтгэмж	23	20	-3	17,8	12,5	(5,3)	70,2
Сувиллын зардал	19	16	-3	4,9	1,8	(3,1)	36,7
	<b>121</b>	<b>116</b>	<b>-5</b>	<b>424,0</b>	<b>387,5</b>	<b>(36,5)</b>	<b>91,4</b>

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 36,5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь аж ахуй нэгж, байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг жил бүр дээшлүүлж үйлдвэрийн осол буурсантай холбоотой байна.

Ажилгүйдлийн даатгалын санд хамрагдагсадыг төсөвтэй нь харьцуулж харуулбал:

/Хүснэгт 6/

	Хүний тоо				2017 он /сая.төг/		
	2016 он	2017 он	Өсөлт, бууралт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Биелэлт хувь
Ажилгүйдлийн тэтгэмж	318	398	80	499,9	499,5	(0,4)	99,9
Сургалтын төлбөр		21	21	1,7	1,0	(0,7)	58,8
	<b>318</b>	<b>419</b>	<b>101</b>	<b>501,6</b>	<b>500,5</b>	<b>(1,1)</b>	<b>99,8</b>

Ажилгүйдлийн тэтгэмж авах иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80 иргэнээр нэмэгдсэн нь улс орны эдийн засгийн хямрал, яам, газар хэлтсийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтүүдтэй холбоотой байна. 2017 онд сургалтын байгууллагатай гэрээ хийж ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох тухай хуулийн дагуу ажилгүй иргэдэд сургалтын зардал олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын санд хамрагдагсадыг төсөвтэй нь харьцуулж харуулбал:

/Хүснэгт 7/

	Хүний тоо				2017 он /сая.төг/		
	2016 он	2017 он	Өсөлт, бууралт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Биелэлт хувь
Эмчилгээ, үйлчилгээ	80127	107348	27221	4149,3	4025,5	(123,8)	97,0
Эмийн үнийн хөнгөлөлт	34812	49664	14852	1131,4	1122,6	(8,8)	99,2
	<b>114939</b>	<b>157012</b>	42073	<b>5280,7</b>	<b>5148,1</b>	(132,6)	97,5

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 132,6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс бага гарсан, мөн сумдын эмийн сангуудад эмийн хангалт дутагдалтай байгаагаас хөнгөлөлттэй эм бага олгогдсон зэргээс шалтгаалсан байна.

## 2.2 Сангуудын орлого, зарлагын гүйлгээн дээр сумын Засаг дарга гарын үсэг зурсан байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2017 онд шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэргээс Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/151 тоот тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу 140 иргэний материалыг түүвэрлэн татаж үзэхэд тэтгэврийн хувийн хэргийн бүрдэлт сайн хийгдсэн, эмх цэгцтэй, код шифртэй хэдий ч зарим тэтгэвэр тогтоолтын өргөдлийн маягтад хүлээн авсан байцаагчийн гарын үсэг, тэтгэвэр тогтоолтын хуудас дээр хянасан байцаагчийн гарын үсэг тус тус зурагдаагүй байна.<sup>1</sup>

Тэтгэмжийн даатгалын сангаас 2017 онд хөдөлмөрийн чадвар түр алдсан 2651, жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгогдсон 1417 эмнэлгийн хуудаснаас 364-ийг түүвэрлэн, оршуулгын тэтгэмж авсан 246 хүнийг нас барсны гэрчилгээтэй нь тулгаж үзэхэд зөрчил илрээгүй.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран гэрээ байгуулж нас барсан иргэдийн мэдээллийг солилцон ажилласан байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү, бүртгэл, орлого хяналтын тасгаас ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн албанд мэдэгдэхгүйгээр ажилд орсон эсэхийг тогтмол шалгадаг байна. Ажилгүйдлийн даатгалын сангаас 2017 онд ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн материалыг

<sup>1</sup> Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 163 тоот тушаалаар батлагдсан журмын

4.1. Тэтгэвэр тогтоох ба хянах:

4.1.1. Сум/хороо/-ын нийгмийн даатгалын байцаагч нь тэтгэвэр тогтоолгохоор ирүүлсэн энэ журмын 3.1, 3.2, 3.3, 3.4-д заасан баримт бичгийн бүрдэл, эрх үүсэх үндэслэлийг тухайн иргэнийг байлцуулан уг баримт бичгийг эрх зүйн дагуу бүрэн бүрдэж “тэтгэвэр тогтоох үндэслэл хангагдсан” гэж үзвэл тэтгэврийн хувийн хэрэг /НД№15/ нээж, бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авсан байцаагч, хүлээлгэн өгсөн иргэн гарын үсэг зурна.

4.1.2. Сум /хороо/-ын нийгмийн даатгалын байцаагч нь энэ журмын 4.1.1-д заасан баримт бичгийг үндэслэн хүн тус бүрээр тэтгэвэр тогтоох нөхцөлийг компьютерийн нэгдсэн мэдээлэлд оруулан тэдгээрийн “тэтгэвэр тогтоолтын хуудас”-ыг тэтгэвэр бодсон цалин/НД№17/-ийн хамт хэвлэж тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргана.

4.1.3. Хэлтэс, тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч нар энэ журмын 4.1.2-т заасны дагуу иргэнд шинээр тогтоосон тэтгэврийн хэмжээг хянаж, тухайн иргэний “тэтгэвэр тогтоолтын хуудас”-д гарын үсэг зурж, хэлтсийн тэмдэг дарж баталгаажуулна.

шалгаж үзэхэд 13,9 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба эдгээр зөрчилд дотоод хяналт шалгалтаар акт тавигдсан байна.

Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн албанд мэдэгдэхгүйгээр ажилд орсон зөрчил гарч байгаа нь нийгмийн даатгалын сангийн программ нь ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэн тухайн хугацаанд ажилд орж цалин хөлсний шимтгэл шивэгдэж болдогтой холбоотой байна. Өөрөөр хэлбэл сангийн программ дээр тухайн даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмжийн хугацаа дуусаагүй тухай чек асдаггүйтэй /хориг байхгүй/ холбоотой байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2017 онд үйлдвэрлэлийн ослын актаар 5 хүн тэтгэвэр тогтоолгосон байна. Тэтгэврийн хувийн хэргийг татаж авч шалгахад хууль, журмын дагуу тогтоосон байна.

Сумдын нийгмийн даатгалын байцаагчдын санхүүгийн баримт материалыг шалгах явцад сангийн орлого зарлагын гүйлгээн дээр тухайн сумын Засаг дарга нэгдүгээр гарын үсэг зурж гүйлгээ хийж байгаа нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайд, Санхүү, эдийн засгийн Сайдын 2003 оны 45/21<sup>2</sup> дүгээр тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх” журмын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Нийгмийн даатгалын сангуудын 2017 оны 12 дугаар сарын 3 ширхэг нийт 2,1 сая төгрөгийн зарлагын төлбөрийн хүсэлт дээр нэгдүгээр гарын /хэлтсийн даргын/ үсэггүй гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5<sup>3</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

### **III Бүлэг. Сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.**

#### **3.1 Сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.**

Нийгмийн даатгалын хэлтэст 2017 онд НДЕГ-аас дотоод хяналт шалгалт ирээгүй, төлөвлөгөө гүйцэтгэлийг цахимаар хянаж хүлээн авсан байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс 2017 онд өөрсдөө хийх дотоод хяналт шалгалтанд нийт 58 байгууллага 649 иргэдийг хамруулна гэж төлөвлөснөөс 78 байгууллага, 1028 хүнийг хамруулж нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт төлөлтөөр 59 байгууллагын 858 хүнд 79,8 сая төгрөгийн төлбөр, алданги тооцсон байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын нийгмийн хамгааллын улсын байцаагч нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтад жил бүр хяналт шалгалт хийсэн байна. 2017 оны сангийн баримтанд хийсэн хяналт шалгалтаар 4 зөвлөмж өгч ажилласан байна. Үүнд:

<sup>2</sup> Нийгмийн даатгалын сан болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны данснаас зарлагын гүйлгээг гүйцэтгэхдээ нийгмийн даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэгтэй төлбөр тооцооны баримт бичигт үндэслэнэ.

Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын орлого, зарлагын гүйлгээг төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ.

<sup>3</sup> Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.

- Тэтгэвэрийг илүү, дутуу олгох зөрчилд хяналт тавьж ажиллах,
- Дотоод хяналт шалгалтын тайлангаа улирал бүр аймгийн Мэргэжлийн хяналтын газарт ирүүлж байх,
- Тэтгэвэр тогтоолтыг хянаж буй шат шатны хяналтыг сайжруулах,
- Гурванзагал сумын нийгмийн даатгалын санд хамтарсан шалгалт хийх,

### **3.2 Хяналт шалгалтын ажлын үр дүнгийн хэрэгжилт 80 хувьтай байна.**

Нийгмийн даатгалын хэлтсээс 2017 онд хийсэн дотоод хяналт шалгалтанд нийт 78 байгууллага, 13624 хүнийг хамруулж нийгмийн даатгалын шимтгэл ноогдуулалт төлөлтөөр 59 байгууллагын 858 хүнд 79,8 сая төгрөгийн төлбөр, алданги тооцсон байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар төлбөр, алдангийн 79,6 сая төгрөгийг барагдуулж 99 хувийн биелэлттэй байна.

Мэргэжлийн хяналтын газраас 2017 оны сангийн баримтанд хяналт шалгалт хийж нийгмийн хамгааллын улсын байцаагч тэтгэвэрийг илүү, дутуу олгох зөрчилд хяналт тавьж ажиллах, дотоод хяналт шалгалтын тайлангаа улирал бүр аймгийн Мэргэжлийн хяналтын газарт ирүүлж байх, тэтгэвэр тогтоолтын шат шатны хяналтыг сайжруулах, гурванзагал сумын нийгмийн даатгалын санд хамтарсан шалгалт хийх зэрэг зөвлөмжүүдээс гурвыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийн тайланг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн ажилласан байна.

### **ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Сангуудын орлогыг төлөвлөхдөө хуульд заасан албан журмын даатгуулагчдыг даатгалд бүрэн хамруулаагүй байна.
2. Сумдад сангуудын төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй байна.
3. Сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

### **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ө.Амарсайхан, ахлах нягтлан бодогч Д.Байгалмаа нарт зөвлөж байна. Үүнд:

1. Сангийн орлогыг төлөвлөхдөө албан журмын даатгуулагчдыг бүрэн хамруулах.
2. Сумдын сангуудын орлого, зарлагын гүйлгээг гүйцэтгэхдээ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайд, Санхүү, эдийн засгийн Сайдын 2003 оны 45/21 дүгээр тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх” журмыг баримтлан ажиллах.

Аудитаар нийт 117,4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.





ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНЦЛАГ  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

21073, Чойбалсан, Дорнод аймаг  
Утас/Факс: 7058-4102


2018.09.24 № 485

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Тус хэлтсийн 2017 оны нийгмийн даатгалын сангуудын үйл ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллах болно.

Хүлээн авч танилцахыг Танаас хүсье.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Ө.АМАРСАЙХАН



22 693